

ЭВТАНАЗИ БУЮУ ҮХЭХ ЭРХИЙН ТУХАЙ ФИЛОСОФИ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Б.Дагзмаа /доктор (Ph.D)/

Б.Мөнхжавхлан /магистр/

МУИС, Философи, шашин судлалын тэнхим

Түлхүүр үгс: Хүний эрх, сонголт, үхэх эрх, ёс суртахуун

Euthanasia гэдэг нь эртний Грек гаралтай үг бөгөөд Eu-сайн сайхан, thanatos-үхэл гэсэн утгыг илэрхийлдэг. Философийн сурах бичигт дурдсанаар “эвтанази” гэдэг нь амар үхэл гэсэн утгатай үг юм. Харин орчин үеийн анагаах ухаанд, тухайлбал анагаах ухааны ёс зүйд дээрхи ойлголт нь найдваргүй болсон хүнийг үхэлд зовлонгүй хүргэх гэсэн утга санаа илэрхийлэх болжээ¹. Үүнийг нэг талаас “зовлонгүй үхэл” эсхүл “зовоохгүйгээр үхүүлэх” гэж ойлгож болно.

Эрт дээр үеэс өөр өөр улс оронд эвтаназийг хүлээн зөвшөөрөх аль эсвэл хориглон цагдах хандлага байсаар ирсэн. Тухайлбал, эртний Месопотамид Ассирийн эмч нар эвтаназийг хориглодог байсан атал эртний Энэтхэгт эдгэрэшгүй өвчин туссан хүнийг Ганга мөрөнд живүүлдэг ёс үйлчилж байжээ². Эртний Ромд эвтаназийг аллага хэмээн үздэг байсан. Харин Спартад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрвөл хүүхдийг хөнөөдөг байсан бөгөөд түүнийгээ зовлонг амьдралаас нь ангижруулж, нийгмийг шаардлагагүй төвөг бэрхшээлээс хамгаалж байна гэж тайлбарладаг байв. Иудаизм болон бусад

авраамик³ шашинд хүний амийг бурхны өглөг хэмээн үзэж аливаа хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад эрүүл хүмүүстэй адил хүнийхээ үндсэн эрхийг эдлэх ёстой гэдэг байв. Тэд, бурхан хүний амийг хэрхэхээ зөвхөн өөрөө л шийдэх эрхтэй гэж үздэг байжээ. Хожим Германы нацист дэглэмийн үед улс төрийн хоригдлууд, хомосексуал хүмүүс болон еврей, польш, орос зэрэг үндэстнүүдийг хөнөөж, герман үндэстнийг цэвэрлэх зорилгоор эвтанази нэрийн дор хүнд өвчтэй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй, оюун ухааны хомсдолтой хүүхдүүдийг үй олноор нь алж байсан түүх бий.

Эвтанази гэдэг нэр томъёог ромын түүхч Светоний Август Цезарийн үхлийн тухай бичихдээ анх хэрэглэсэн гэдэг. Харин хожим энэ үгийг шинэ үеийн философич Ф.Бэкон эдгэрэшгүй хүнд өвчтэй хүний амьдрах хугацааг уртасгах зорилгоор эмчилгээг үргэлжлүүлэх гэсэн санааг илэрхийлж анагаах ухааны хэллэг болгон ашиглажээ.

Академич Ц.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” хэмээх бүтээлдээ “Зовиургүй үхүүлэх (гр. Euthanatos орос. эвтаназия)

¹Философи эхлэн сурах бичиг. УБ., 2000. Нээлттэй философи нийгэмлэг

² <http://www.life.org.nz/euthanasia/abouteuthanasia/history-euthanasia1/>

³Иудаизм, христын шашин болон исламыг ийнхүү нэрлэдэг юм.

- архаг өвчний төгсгөлийн шатанд байгаа, тухайн цаг үеийн анагаах ухааны мэдлэгийн хүрээнд эмчлэн эдгэрүүлэх боломжгүй өвчтөний шаналгааг хөнгөлж, тарчилж зоволгүй нас барахад нь туслах үйлдэлд эмчлэгдэхгүй, эдгэрэхгүй болсон өвчтөний хүсэлтээр түүний зовиур шаналгааг ямар нэгэн үйлдэл буюу хэрэгслээр үхлийг түргэсгэх, хиймлээр сэхээн амьдруулах арга хэмжээг зогсоох. Гадаадын зарим улсад хууль ёсны болгосон байна⁴ гэж эвтаназийг тайлбарлажээ.

Өнгөц харахад эвтанази нь цэвэр анагаах ухааны хүрээнд л яригдах асуудал мэт сэтгэгдэл төрүүлдэг боловч уг чанартаа энэ нь эрх зүй, анагаах ухаан, шашин, биоэтик, болон философи зэрэг шинжлэх ухааны ба нийгэм, хүмүүнлэгийн олон салбарын хэлэлцүүлэгийн төвд оршиж, тухайн салбарынхаа чухал, ээдрээтэй, нэг мөр шийдэх боломжгүй далд асуудлуудыг “илчилж”, хүний жам ёсны амьд явах эрхийн өөр тал, харилцааг илэрхийлдэг юм. Тухайлбал, манайд эвтаназийн асуудлыг эрх зүй болон анагаах ухааны аспектын үүднээс харьцуулан судалсан бүтээлүүдээс анагаах ухааны доктор М.Цэрэнбатын 2012 онд бичсэн “Эвтанази ба үхэх эрх” хэмээх нэг сэдэвт зохиолыг онцлон тэмдэглэж болно.

Мөн магистр Б.Одгэрэлийн 2014 онд бичсэн “Эмнэлэгийн эрх зүйн Монгол болон олон улс дахь эрх зүйн зохицуулалт: Эвтаназийн эрх зүйн зохицуулалт” сэдэвт магистрийн судалгааны ажлыг энд дурдах шаардлагатай билээ.

Харин проф. Ц.Гомбосүрэн, доктор

⁴ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ., 2010. х.216

Д.Тунгалаг, доктор М.Золзаяа⁵ нар эвтаназийг ёс суртахууны философийн болон биоэтикийн асуудал болохынх нь хувьд тус тус судлан үзсэн байна.

Философи сэтгэлгээний түүхэнд эртний грекийн философич Платон, Аристотелиос эхлэн Аквины Фома, Т.Мур, Ф.Бэкон, Ф.Ницше, К.Маркс, М.Хайдеггер зэрэг философичид хүний амьд явах эрхийг “амар үхлийн” асуудалтай холбон үзэж, өөр өөр байр суурийг илэрхийлж байжээ⁶.

Ёс суртахууны философид эвтаназийг дараах байдлаар ангилан тодорхойлдог:

1. Эмч хийх ёстой эмчилгээгээ ухамсартайгаар хэрэгжүүлэхээ больсноор өвчтөн хурдан үхэж, зовлонгоос ангижрахыг идэвхгүй эвтанази гэнэ.

2. Эмч тодорхой зорилготойгоор урьдаас гаргасан шийдвэрийн дагуу эмнэлэгийн арга хэрэгслүүдийг ашиглан өвчтөнг түргэн үхүүлэх нь идэвхитэй эвтанази⁷ юм.

3. Өвчтөн хүний өөрийнх нь хүсэлтээр амьдралыг нь таслан зогсоохыг сайн дурын эвтанази гэнэ.

4. Өвчтөн өвчний улмаас өөрийн хүсэлтээ илэрхийлж чадахгүй, харин ойр дотны хүмүүс нь түүний өмнөөс хүслийг нь илэрхийлэн үхүүлэх шийдвэр гаргахыг сайн дурын бус эвтанази гэдэг. Эвтаназийн эхний хоёр төрөл нь эмч хүний, сүүлийн хоёр нь өвчтөний байр суурийг илэрхийлдэг юм.

⁵ Ц.Гомбосүрэн. “Ёс зүй”. УБ., 2008; Д.Тунгалаг. “Ёс зүй”. УБ., 2013; М.Золзаяа. “Ёс зүй”. УБ., 2014

⁶ Эвтаназийг хүлээн зөвшөөрдөггүй болон хүлээн зөвшөөрдөг хандлагуудыг тайлбарлахдаа эдгээр философичдын үзэл санааг тодорхойлох болно.

Дээрхи дөрвөн төрөл нь эвтаназийн дараах дөрвөн хэлбэрийг бий болгодог.

1. Сайн дурын идэвхтэй
2. Сайн дурын идэвхгүй
3. Сайн дурын бус идэвхтэй
4. Сайн дурын бус идэвхгүй”⁸

Хуульч, эмч доктор М.Цэрэнбат “эмчилгээгүй эрүүл болох найдваргүй болсон өвчний улмаас өвдөж шаналж буй хүнийг нас барахад нь хэрэв ар гэрийнхэн нь “идэвхтэй” (хүчтэй үйлчилгээтэй эм, тариа өндөр тунгаар өгөх г.м) байдлаар тусалсан бол энэ нь гэмт хэргийн шинж чанартай болох ба харин эмч дээрх үйлдлийг хийсэн бол эвтанази гэж тодорхойлогдоно”⁹ гэж “Эвтанази ба үхэх эрх” гэдэг нэг сэдэвт бүтээлдээ бичжээ. Ийнхүү эвтаназийн асуудал салбар хоорондын шинжтэй, олон соёлын уулзварт оршиж байдаг учир түүнийг юуны өмнө философи, арга зүйн үүднээс эргэцүүлэн ухаарах хэрэгцээ шаардлага байгаа билээ.

Эвтаназийг хүний бие даасан байдлын илэрхийлэл хэмээн үзэж эрх зүй, ёс суртахууны үүднээс зөвтгөдөг мөн нөгөөтэйгүүр энэ нь хүний жам ёсны амьд явах эрхийг зөрчдөг хэмээн үгүйсгэдэг үндэслэлүүдийг гаргаж өгдөг ялгаатай үзэл баримтлалуудыг юуны түрүүнд авч үзье.

⁷ Стивен Х. Гиффисийн тодорхойлсноор (судлаач М.Цэрэнбатын дурдсанаар) эвтанази нь *догтроо идэвхтэй (active euthanasia)* болон *идэвхгүй (passive euthanasia)* гэсэн хоёр хэлбэртэй. Идэвхтэй эвтанази гэдэг нь барууны орнуудын шүүхийн практикт нэр томъёоны хувьд олон янзаар хэрэглэгддэг жишээлбэл *mercy killing* буюу ‘уучлал эрж алах’, *assisted suicide* буюу дэмжлэгтэйгээр амиа хорлох зэрэг бөгөөд эдгээр нэр томъёонууд нь бүгд утга нэг юм.

⁸ Философи эхлэн сурах бичиг. УБ., 2000, Нээлттэй философи нийгэмлэг. х. 264

⁹ М.Цэрэнбат. Эвтанази ба үхэх эрх. УБ., 2012. х.12

Эвтаназийг хүлээн зөвшөөрдөггүй хандлага:

Философичид эрт дээр үеэс эвтаназийн талаар өөр өөрийн байр суурийг илэрхийлсээр ирсэн. Тухайлбал, эртний грекийн сэтгэгч Платоны зохиолд бичигдсэнээр эртний анагаагч бурхан тэнгэр Асклепи хэн нэгний өвчин нь ямар ч эдгэрэх найдлагагүй, эмчилгээ нь үр дүн өгөхгүй нь илт болж тухайн хүнд ч, нийгэмд ч өгөөжгүй бол эмч эмчилгээгээ зогсоохыг зөвшөөрдөг ажээ. “Байгалиас эрүүл саруул биетэй төрсөн хийгээд зөв хэмнэлээр амьдардаг хүн нэгэн сонин өвчнөөр өвдлөө гэж бодоход нийгмийн ашиг сонирхлыг хөсөрдүүлэхгүйн тулд Асклепи тэдгээр хүмүүст амьдралынхаа хэмнэлийг өөрчлөлгүйгээр эм тан болон ханах зэрэг эмчилгээгээр өвчнийг эмчлэх хэрэгтэй гэж зөвлөдөг байжээ. Хэрэв бүх насных нь туршид үргэлжлэх дотор эрхтний өвчин байваас Асклепи жаахан ч атугай зовлонг нь нимгэлэх оролдлого хийдэггүй байсан бөгөөд амьдралынх нь хэмнэлийг үл мэдэг өөрчилж тухайн хүний насыг нь уртасгадаг байжээ. Харин хүний амьдрах ёстой хугацааг гүйцэж үл чадах тийм богино настай хүнийг Асклепи өөртөө ч тэр нийгэмд ч тэр огт хэрэггүй тул эмчилээд ч хэрэггүй гэж үздэг байв” хэмээн бичсэн юм.¹⁰

Харин Платон өөрөө бол эвтаназийн эсрэг үзэлтэй хүн байжээ. Тэрээр “Хуулиуд” зохиолдоо эмч хүн үйлчлүүлэгчдээ амьдралыг нь зогсоохоор эм өгсөн байвал түүнд цаазаар авах ял өгөхийг зөвлөж байв. Бас хүний амиа хорлох явдлыг ч тэрээр мөн эсэргүүцсэн

¹⁰ Платон. Төр улс. УБ., 2005. х. 81

байдаг. Түүнийхээр амиа хорлох нь бурхан тэнгэрийн хүсэл зоригийн эсрэг зүйл учир түүнийг хүлээн зөвшөөрч болохгүй гэж үзсэн атлаа “Төр улс” зохиолдоо тэрээр өвчтөн нэгэнт хэвийн амьдарч чадахгүй зовж байвал амьдрах хугацааг нь уртасгахын тулд эмчилгээ хийх хэрэггүй гэжээ. Эндээс харахад Платон идэвхтэй эвтаназийг үгүйсгэж, идэвхгүй эвтаназийг зөвшөөрч байна.

Харин пифагорчууд сүнс мөнх бөгөөд нэг биеэс нөгөө биед шилждэг тухай үзэлд итгэдэг, хүний амьдралын үнэ цэнийг шашны үнэлэмжийн үүднээс тодорхойлж байсан учир амьдралыг сайн дураар төгсгөх асуудлыг хүлээн зөвшөөрдөггүй байжээ. Тэднийхээр амьдрал бол ариун зүйл учир мэс заслын үйлийг ч хориглох хэрэгтэй гэж үздэг байв. Ер нь шашны үүднээс эвтаназид эсрэг үндэслэл дэвшүүлэхдээ хүний амьдрал, үхэл бол бурхан тэнгэрээс хамааралтай учир эвтанази хийх нь нүгэл байдаг. Иймд хүн өөрийн амьдрах, үхэх хувь заяагаа шийдэх эрхгүй ажээ.

Харин Аристотель “Эвдемийн ёс зүй”, “Никомахын ёс зүй” зэрэг зохиолууддаа эвтаназийг амиа хорлох явдалтай адилтан өгүүлж, амиа хорлох нь ядуурал, зовлонгоос айж байгаа хэрэг мөн бөгөөд энэ нь зоригтой биш хулчгар хүний л хийх ажил юм гэжээ.

Анагаахын шинжлэх ухааны эцэг гэж өргөмжлөгдсөн эртний Грекийн эмч Гиппократ идэвхтэй эвтаназийг эрс эсэргүүцэж эмч нарыг үхэлд хүргэх эмийг хүнд өгөхийг хориглосон хэдий ч тэрээр Платонтай адил идэвхгүй эвтаназийг зөвшөөрдөг байжээ. Тэрээр эдгэрэшгүй хүнд өвчтэй хүнийг эмчлэхгүй байхыг

зөвлөдөг байв. Гэхдээ тэрээр амьдралын зөрчиж болшгүй хуулийг хүндэлдэг гэдгээ харуулж, мөн эмнэлгийн мэргэжилтнүүдийг эмчилгээний алдаа гаргахаас нь хамгаалж тийнхүү бичиж байжээ.

Дундад зууны үеийн сэтгэгчид болох Аквины Фома, Аврелий Августин нар, хэнд ч хэн нэгний амь насыг хөнөөх эрх байхгүй бөгөөд өөрийнхөө амийг егүүтгэнэ гэдэг ч бурхан тэнгэрийн өмнө хүлээсэн үүргээ зөрчиж, нүгэл үйлдэж буй хэрэг гэж үзсэн.

XVII зууны үеийн философич Спиноза: ажил албаа сонгох, гэрлэх, хаана амьдрах, хүүхэдтэй болохоо шийдэх эсэх нь хүний сэтгэл хөдлөлийн гэхээс илүүтэй рациональ сонголт байдаг. Тэгвэл үүнээс илүү үлэмж зүйл болох амьдрах хүсэл нь хүний уг чанарын гол шинж бөгөөд хүмүүс өөрсдийгөө хөнөөх, амьдрахыг хүсэхгүй байх эсэхээ оюун ухаанаар шийддэггүй гэж үзжээ. Энэхүү үзлээр бол үхэхийг хүсч байна гэдэг нь ухамсарт рациональ алхам биш юм. Яг ижил нөхцөлд буй хүмүүсийн зарим нэг нь үхэхийг хүсч байхад зарим нь амьдрахын төлөө тэмцэж байдаг учир энд рациональ үндэслэл байхгүй гэж тэрээр үзэж байв.

XVIII зуунд Кант “чиний хүсэл зоригийн максима (ёс суртахууны зарчим) зөвхөн чинийх байхын зэрэгцээ мөн бүх нийтийн хууль тогтоомжийн зарчим байхаар биеэ авч явж үйл хөдлөлөө тохируулж бай”¹¹ гэсэн байдаг. Эндээс харахад эвтанази үйлдэж, хэн нэгэнд үхэлд хүргэх тариа хийж аль эсвэл хэн нэгний эмчилгээг зогсоож байгаа бол энэ үйлдлээ

¹¹ Steven Luper. *A Guide to Ethics*. USA, 2002, p.154

бас бүх нийтээр баримтлах универсаль хууль мэт авч үзэн, бусдад төдийгүй өөрт хамаатуулан үйл ажиллагааныхаа чин эрмэлзлэл болгоно гэсэн үг.

Гэтэл Кантын хувьд ёс суртахууны дээд үнэлэмж бол хүн мөн бөгөөд тэрээр эмпирик түвшний аз жаргал, сайн сайхан амьдрал гэдгээс дээгүүрх зүйл. Бидний үнэ цэнийг амьд байгаа маань баталж өгдөг. Иймд рациональ ахуйн хувьд бидний гол зорилго бол өөрийгөө хадгалж, авч үлдэх явдал бөгөөд ямар ч нөхцөлд хүн хэдий зовж байв ч эвтанази хийлгэх, амиа хорлох зэрэг нь хүний амьдралын суурь үнэлэмжид нийцэхгүй гэж үзсэн нь түүнийг эвтаназийг эсэргүүцдэг үзэлтэйг батлан харуулж байна.

Эмчлэгдэх найдваргүй өвчтөн болон түүний ар гэрийнхэн эвтаназийг биш харин түүнээс өөр альтернатив арга замуудыг хайх ёстой гэж эвтаназийг шүүмжилж байгаа хүмүүс үздэг. Тэдний санал болгож буйгаар бол өвчин намдаах эмчилгээг үргэлжлүүлэн хийхийн сацуу зарим тохиолдолд өвчтөнг **буяны** эмнэлэгт (hospice) хэвтүүлж хөнгөвчлөх үйлчилгээ үзүүлэн эмчилгээг хийсээр байх ёстой гэж үздэг.

Хөнгөвчлөх тусламж гэдэг нь илааршуулах эмчилгээ ямар ч үр дүнгүй болсон өвчтөнүүдэд үзүүлэх бүх төрлийн идэвхитэй тусламжийг хэлнэ.¹² Зөвхөн эдгэшгүй хүнд өвчин туссан гэдгээр нь өвчтөнд эвтанази хийж болохгүй гэдэг юм.

¹² Ц. Лхагвасүрэн, Д. Одонтүяа. Хөнгөвчлөх үйлчилгээний боловсролын тогтолцоо. /Эрдэм шинжилгээний өгүүлэл / <http://www.mongolmed.mn/article/4925>

Хөнгөвчлөх тусламжийн үйлчилгээний санаа XVII зууны үеийн философич Ф.Бэконы эвтаназийн тухай үзэлд дурдагддаг.

Тэрбээр хүнийг эдгээж, амьдралыг уртасгах нь анагаах ухааны зорилго гэж үзэж байсан юм.

Ер нь эвтаназийг хүлээн зөвшөөрдөггүй хандлага нь шашны үүднээс болон мэргэжлийн ёс зүйн үүднээс хамгийн хүчтэй тавигддаг юм. Эдгээр үзэл санаанаас харвал эвтаназийг үгүйсгэгчид:

1. Хүний амийг бурхан тэнгэрээс хамааралтай гэж үздэг. Иймээс түүний амьдралд хөндлөнгөөс оролцож болохгүй гэдэг. Хүний амь бурхны мэдэлд байдаг учир хэрхэхийг зөвхөн бурхан шийднэ.

2. Ихэнх өвчинг анагаах боломж байх ёстой учир эвтанази хийх нь ухаалаг сонголт биш. Харин өөр боломжит сонголтуудыг хэрэгжүүлэх ёстой. Эмчлүүлэгчид буруу онош тавьсан байх эрсдэлтэй бөгөөд нөгөөтэйгүүр шинжлэх ухааны мэдлэг, хөгжил улам дэвшилттэй болж буй өнөө үед шинээр эмчилгээ бий болж, найдваргүй гэгдсэн хүмүүсийг эмчлэх шинэ боломжууд нээгдэж болзошгүй юм.

3. Эвтаназийг хийх нь өөрийгөө илэрхийлж чадахгүй болсон хүнд сонголт өгөхгүй байх эрсдэлтэй. Ингэснээр тухайн хүн сайн дурын бус идэвхтэй эвтаназийн золиос болж болзошгүй байдаг.

4. Нэгэнт найдваргүй хүнд өвчтэй болсон хүн үнэтэй эм, тариа хэрэглэж, асрамж сувилгаа шаардан, янз бүрийн амьдрал дэмжих төхөөрөмж хэрэглэхээ зогсоож эвтанази хийлгэх нь бусдад илүү

боломж олгох нийгмийн үүрэг гэж ойлгох явдал бий. Энэ нь тухайн хүнд өөрөө үхэхийг хүсээгүй ч, нийгмийн үүрэг гэдэг ойлголтоос үүдэж эвтанази хийлгэх хүсэлт тавихад хүрч магадгүй юм.

5. Амиа хорлох явдал улс орнуудад, нийгэмд гарч байдаг үзэгдэл юм. Энэ үүднээс эвтаназийг хуульчлах нь зайлшгүй зүйл биш. Хэрэв хүмүүс амиа егүүтгэхээр шийдсэн гэвэл тэд ямар нэг аргыг аль хэдийнэ бодож олсон байдаг. Эвтаназийг хуульчилснаар хүмүүс хэн нэгнийг амиа егүүтгэхэд оролцохыг ятгаснаас амиа хорлохыг илүүд үзэж болох билээ.

6. Хүмүүс ихэнхдээ эдгэхгүй, тэсвэрлэшгүй өвдөлт бүхий хүнд өвчинг даван туулах арга бол эвтанази гэж үздэг. Гэхдээ өвчинг нь намдааж, өвдөлтийг бууруулах талаар мэдлэггүй байх нь амьдралаа төгсгөх шийдвэрт хүргэх эрсдэлтэй. Харин түүний оронд хөнгөвчлөх тусламж үзүүлж, буяны эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх, өвчинг нь намдаах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зэргээр эвтанази хийлгэх бодлыг нь өөрчлөх арга хэмжээ авч болно.

7. Тухайн хүн, эмнэлэгийн сэтгэл зүйн орчин, эмчилгээ зэргээс үүдсэн клиникийн депресст автаж эдгэж, эмчилж болох өвчнөө эвтанази хийлгэж шийдэж болзошгүй байдаг. Иймд зөв оношлохоос гадна сэтгэл зүйн эмчилгээг давхар хийж байх хэрэгтэй.

8. Эмч нарт эвтанази хийхийг зөвшөөрөх нь тэднийг мэргэжилдээ, өөртөө итгэлтэй байх байдлыг нь эрсдэлд оруулдаг. Энэ үндэслэгээг дэвшүүлэгчид, хэрэв эвтаназийг хуульчилбал тусгай

мэргэжилтнүүдийг бэлтгэх хэрэгтэй гэж үздэг. Эмч нар хүнд өвчтэй хүмүүсийн өвдөлтийг намдааж, тэдэнд үхлийн эсрэг тэмцэхийг ятгаж зөвлөдөг атал, эмчлүүлэгчдээ эвтанази хийх нь зөрчилт байдлыг бий болгож байгаа юм. Улмаар эвтанази нь яваандаа эмч нарт хүний амьдралыг шийдэх эрх өгч эвтаназийг хийх явдлыг нэмэгдүүлж болзошгүй юм. Энэ үйлдлийг хянах бололцоогүй гэж үзэх хандлага бас бий.

9. Зарим тохиолдолд амиа егүүтгэхийг хүссэн хүмүүст яг тухайн мөчдөө өөрийнхөө шийдвэрт эргэлзэх нөхцөл бий болдог. Гэтэл тэр үед нэгэнт эвтанази хийгдэх шийдвэр гарсан бол нийгмийн зүгээс тухайн үйлдлийг гүйцээх дарамт шахалт ирэх эрсдэлтэй байдаг. Энэ үед зөрчилт байдал үүсдэг.

10. Хэн нэгний хувьд өөрийнх нь зовлон маш үнэ цэнэтэй санагдаж болох юм. Өөрөөр хэлбэл тэдний хувьд зовж, нажидаа эдэлж буй нь өөрийн нүглээ наманчилж байгаа баатарлаг үйл бөгөөд ингэснээр хойд насандаа илүү сайн амьдрахын төлөөс хэмээн сэтгэж болно.

Энэ мэтээр эвтаназийг үгүйсгэдэг философийн, шашны, мэргэжлийн ёс зүйн, эрх зүйн зэрэг үндэслэлүүдийг дэвшүүлэх шаардлага гардаг.

Эвтаназийг хүлээн зөвшөөрдөг хандлага:

Эвтаназийг дэмждэг үзэл санаанууд ихэвчлэн хүний эрхийн үзэл баримтлалууд, ёс зүйн прагматик, утилитари үзлийн хүрээнд гарч байдаг. Энэ санаанууд түүхийн тодорхой цаг үед холбогдох үндэслэлүүдтэй байв.

Тухайлбал Томас Мур (1516) “Утопи” зохиолдоо “эдгэшгүй хүнд өвчтэй хүмүүстэй хамтдаа суун ярилцаж, тэднийг тайвшруулах арга хэрэгслүүд бий. Гэвч хэрэв өвчин нь нэгэнт эдгэхгүй, бас үргэлжилсэн их өвдөлт зовлонтой байвал, ...энэ өвдөлтөөс хагацахын тулд хэн нэгнийг амиа егүүтгэхэд туслахыг гуйхыг нь зөвшөөрөх хэрэгтэй¹³ гэжээ. Гэхдээ энд зөвхөн тухайн хүн өөрөө хүсвэл гэдэг нөхцлийг Мур чухалчилсан байдаг.

Эвтаназийг дэмждэг хүмүүс, эдгэрэшгүй хэрнээ тэсвэрлэх аргагүй өвдөж зовж буй хэн нэгний амьдралыг зориуд үргэлжлүүлж байхаар нэр төртэй үхэхийг нь зөвшөөрөх хэрэгтэй гэж үздэг. Хүн бие даасан байдлынхаа¹⁴ хувьд хэзээ үхэхээ сонгох бүрэн эрхтэй бөгөөд асуудлыг бодлогоор хуульчлах юм бол эвтаназийг хянах боломжтой гэдэгт энэ үндэслэгээг илэрхийлэгчид итгэдэг юм. Энэ санаа XVII, XVIII зууны үеийн философичдын үзэл баримтлалд илэрдэг.

Тухайлбал, Давид Юм: чөлөөт нийгэмд буй хэн боловч хэрхэн үхэхээ сонгох эрхтэй гэжээ. Зарим хүмүүс, энэ эрх нь бусад хүмүүст аюул учруулахгүй байх үүрэгтэй гэдэгтэй уялддаг гэж үздэг.

Хүний эрхэд үндэслэсэн үзэл ёсоор бол хүн үхэх эрхтэй. Үхэл гэдэг бол хувийн шинжтэй бөгөөд бусдад хөнөөл хохиролтой биш учир төр хийгээд бусад хүмүүс хөндлөнгөөс оролцох эргүй. Үүнийг бид либертари үндэслэгээ гэж болно. Эл асуудлыг мөн Ж.Локкийн жам ёсны эрхийн тухай санаа, “бусдын зүгээс үзүүлэх саад тотгор, хязгаарлалт огт

байдаггүй хүрээ” буюу негатив эрхийн хүрээнд хамааруулан үзэж болох юм.

Ф.Ницше харин эдгэшгүй хүнд өвчтэй хүмүүс бусдад түвэг учруулах бөгөөд тэд амьд байх эрхгүй хэмээн эрс хэлж байв.

Харин гедонистууд болон утилитари үзэлтнүүд сайн дурын эвтаназийг зөвшөөрсөн байр суурийг илэрхийлдэг. Утилитаристууд, хэн нэгний үхлээс үүдэж тодорхой тооны хүмүүс аз жаргалтай байж, амьдралын чанар нь нэмэгдэнэ гэж үзвэл “олон хүн жаргалтай байна” гэсэн үндэслэл зөв гэж үздэг. Гэхдээ энэ үндэслэгээний үр дагаварыг нь тооцоолбол олон хүний төлөө нэг хувь хүнийг золиосолж, түүнийг хамгаалах хамгаалалт үгүй болох юм.

Ёс суртахууны үүднээс хэрэв ёс суртахууны үйлдэл зөв бол түүнийг хуулиар зөвшөөрөх ёстой. Утилитаристуудынхаар хууль **ашигтай** бол **зөв** байдаг. Харин хянамгай утилитарист хүн ийм хууль байх нь хамгийн сайн үр дүнтэй байна гэдэгт эргэлзэнэ. Хүнд өвчтэй олон хүн хэдий өөрөө хүсэхгүй байгаа ч эвтанази хийлгэхийг хүсэх болно. Учир нь нэгэнт цаашид эдгэрэхгүй нь тодорхой болсон хүнд эвтанази хийх нь зардал хэмнэж ирээдүйд болон ард үлдсэн гэр бүл төрөл төрөгсөддөө эдийн засгийн бэрхшээл авчрахгүй гэсэн байр суурь түгээмэл болчихвол, тэрхүү түгээмэл үзэл санаанд автаж хүн өөрөө хүсэхгүй байсан ч эвтанази хийлгэх шийдвэр гаргаж болзошгүй юм. Энэ санааг эвтаназийг үгүйсгэдэг үзэл өөрийн үндэслэгээгээ болгодог гэдгийг өмнө нь дурдсан билээ.

Тэд гэхдээ эвтаназийг хуулиар хориглосон байсан ч нууцаар үйлдэгдэж

¹³ Sir Thomas More, *Utopia*, 1997., Dover Publications Inc, p.58

¹⁴ Автоному гэдгийг бие даасан байдал гэж орчуулав.

болзошгүй учир дан ганц хуулиар энэ асуудлыг бүрмөсөн шийдвэрлэх арга хомс гэж хэлдэг. Ийм учраас хэрэв эвтаназийг хориглож байгаа бол энэ шийдвэрийнхээ учир шалтгааныг олон нийтэд сайн сурталчилж байх хэрэгтэй гэдэг байна¹⁵.

Ёс суртахууны талаархи уламжлалт философи онолуудихэнхдээ ёс суртахууны зөв үйлдлийн шалгуурыг нягтлахыг гол зорилгоо болгодог.

Бид тэдгээр онолыг үндсэнд нь 2 хэсэгт хувааж болно. *Эхнийх нь* аливаа зөв үйлдэл ямагт хамгийн сайн үр дагаварыг авчирдаг гэдэг баримтлал буюу консеквентализм юм. Энэ үзэл нь үйлдлийн үр дагавар зөвхөн өөрт нь ёс суртахууны хувьд хамаарах эгоизм, нөлөөг нь хүртсэн хэнд ч болов үр дагавар нь хамаарах универсализм гэсэн хоёр төрлийн үзэл санаанд хуваагддаг. *Удаах нь* деонтологи үзэл бөгөөд энд эрх үүргийн тухай асуудал гарч ирдэг. Хэдий эдгээр нь тусдаа асуудал байдаг боловч тухайлбал эвтанази, цаазаар авах ялын тухай асуудалд хамтад нь авч үзэхээс аргагүй байдаг. Өөрөөр хэлбэл сайн дурын эвтанази хийж буй тохиолдолд эмч үхэх эрхийн сацуу, үхүүлэх үүргийг гүйцэтгэж байдаг.

Универсал консеквентализмын хувьд Ж.С.Милль: сайн үр дагавар гэдэг бол зүгээр л аз жаргал юм. Аз жаргал гэдэг бол таашаал хүртэх, өвдөлтөөс ангид байх явдал. Өвдөлт шаналал гэдэг бол зөвхөн биеийн хувьд биш бас сэтгэл санаанд учирдаг зүйл гэжээ¹⁶.

¹⁵ <http://www.euthanasia.cc/telfer.html>

¹⁶ Доктор Жек Кеворкиан "үхэл, тодорхой нөхцөл байдал буй хүний хувьд тустай зүйл байж болно" гэж итгэж байв. 1990 оноос хойш тэрээр 40 гаруй хүнд амиа егүүтгэхэд нь туслажээ. Түүний үйлчлүүлэгчдийн дийлэнх нь үхэлд хүргэх өвчин туссан байв. Харин тэрээр 1996 оны 3 дугаар сард Жудит Каррен

Энэ үзлээр бол зөв үйлдэл гэдэг нь хүмүүст хамгийн их таашаал амсуулж, хамгийн бага өвдөлт авчирдаг байх ёстой. Сайн үр дагавар гэдэг бол зөвхөн таашаалын хэр их хэмжээнд бус харин чанарт байдаг. Тэгвэл консеквенталист эгоизмын үзлийнх нь хувьд зөв үйлдэл гэдэг бол бидний аз жаргал гэж нэрлэдэг өөрийгөө хөгжүүлэхэд ач холбогдол өгч, хүний рациональ мөн чанараа тэжээн тэтгэж байгаа явдал юм. Иймээс эдгээр зарчмуудыг харгалзаж эвтаназийн асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй гэжээ.

Секуляр үндэслэгээ¹⁷

Секуляр үндэслэгээ илэрхийлэгчид бидэнд буй эрх ямагт бидний үүргээр хязгаарлагддаг гэдэг. Эвтанази хийлгэнэ гэдэг шийдвэр бол гэр бүл, найз нөхөд, эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд нөлөөлдөг ба бид өөрсдийн эрхийн эсрэг, үр дагаварыг нь бас тэнцвэржүүлэх хэрэгтэй гэж үзнэ.

Эндээс харахад эвтаназийг хүлээн зөвшөөрдөг үндэслэлүүдийг дараах байдлаар нэгтгэж болно:

хэмээх эмэгтэйд амиа егүүтгэхэд нь тусласан байна. Энэ эмэгтэйн өвчин үхэлд хүргэхүйц аюултай биш байжээ. Тэр эмэгтэй 2 хүүхэдтэй, 42 настай байв. Гэхдээ тэрээр нөхрийн дарамтад байдаг, сэтгэцийн гүн хямралтай, жин ихтэй, хэт ядаргаанд орсон байжээ. Эвтаназийг сонгох нь тэдгээр зовлонгоос түүнийг ангижруулах арга нь болсон юм. Энэ жишээнээс харахад дан ганц өвчин гэхгүй өөр бусад тохиолдол ч бас эвтанази хийх боломжтой тухай асуудал утилитарист ёс зүйн үүднээс яригддаг ажээ. Judith A. Boss. *Ethics for life*. USA. 1998. P.293

¹⁷ Секуляр ёс зүй гэдэг нь ёс суртахууны философиин салбар бөгөөд логик, оюун ухаан, ёс суртахууны интуиц нь, янз бүрийн шашны ёс суртахуунд эх сурвалжаа хэмээн итгэдэг ер бусын тэнгэрлэг илчлэлт, зааварчилгаанаас үүсээгүй гэж үздэг үзэл юм. Секуляр ёс зүйн тогтолцоо нь нийгмийн гэрээний хэм хэмжээт чанар, ёс суртахууны дотоод үнэлэмж, интуицэд тулгуурласан деонтологи, соёлын ёс суртахууны релятивизм, шинжлэх ухаанч сэтгэлгээ нь ёс суртахууны объектив үнэнийг нээн илрүүлж чадна хэмээн үздэг үзэл баримтлалуудыг өөртөө багтааж байдаг. https://en.wikipedia.org/wiki/Secular_ethics

1. Юуны түрүүнд либерализмыг баримтлагсад эвтаназийг хувь хүний эрхийн асуудлын хүрээнд хамааруулж, негатив эрхтэй холбон тайлбарладаг. Либералистуудын үзлээр хүн хэрэв өөрөө хүсвэл амьдрах асуудлаа өөрөө шийдэх эрхтэй ажээ. Олон хүний бодлоор, хүн өөрийн бие, амьдралаа удирдан чиглүүлэх эрхтэй бөгөөд хэзээ ямар аргаар эвтанази хийлгэхээ өөрөө шийдэх эрхтэй гэж үзэж байдаг.

Зарим хүмүүс үйлчлүүлэгч үхэх эрхтэй байх нь эмч үхүүлэх үүрэгтэй гэсэн санааг илэрхийлэх бөгөөд энд эмчийн бие даасан байдлыг хамгаалах санаа давхар агуулагдаж байна гэж үздэг. Өөрөөр хэлбэл хүний үхэх гэсэн хүсэл, тухайн үйлдлийг гүйцэтгэхэд ‘assisted’ буюу “дэмжлэгтэй” гэсэн ойлголт эвтаназийн гол утгыг тодорхойлж байдаг.

2. Утилитаризмыг баримтлагчид аз жаргалын хамрах хүрээ, хэмжээнээс хамаарч эвтаназийг хийж болно гэж үздэг. Харин үр дагавар хэр байхаас хамааруулж эл асуудалд нухацтай хандахыг зарим утилитаристууд сануулдаг.

3. Зардал хэмнэх зарчим (cost effective principle) - эдийн засгийн хувьд хэмнэлттэй төдийгүй өвчтөн хүний зовлонг нь төгсгөж, ар гэрийнхэнд нь зовлон бэрхшээлийг багасгахын сацуу тухайн хүнд зарцуулах байсан эм хангамжийг эдгэж болохуйц илүү олон өвчтөнд түгээх нь хэрэгтэй гэсэн хандлага бий. Энэ үүднээс хүмүүсийн үхэхийг зөвшөөрөх нь эрүүл мэндийн хангамж хэрэглээг хэмнэх боломж өгдөг. Энэ нь хэдийгээр байж болох үндэслэл ч эрх баригчид энэ талаар шийдвэр гаргаад байдаггүй.

4. Дээр дурдсан зардал хэмнэх зарчмын утга санааг агуулсан “шударга ёсыг хангах” гэсэн өөр нэг тайлбар бий. Энэ үзэл ёсоор, эмнэлэгийн хангамж, нөөц дутагдсан үед хүмүүсийн эрүүл мэнд, амь насанд тодорхой үнэлэмж тогтоож хэнийг амьдруулах, хэнийг эмчлэхийг өөр бусад нь шийдэх нөхцөл үүсч болох юм. Тус үзлийг германы биологич Эрнст Хэжел 1904 онд Дарвины онолд тулгуурлан боловсруулсан байна. Түүний санаа цаашдаа нацизмд биелэлээ олжээ.

5. Эвтаназийг хүлээн зөвшөөрөгчид “сайн үхэл” гэсэн ойлголт мөн ач холбогдол өгдөг. Энэ нь эртний сэтгэгч Цицероны үзэл санаанд илэрдэг. Амар тайван орчинд, өвдөлт зовлонгүйгээр үхэх нь байгалийн хуулийг хүндэтгэж буй хэрэг бөгөөд нэр төртэй үхэл юм гэж тэрээр үзсэн байдаг.

6. Хэрэв эвтаназийг хуулиар хязгаарласан хэвээр байвал зарим хүмүүс хэн нэгний тусламжгүйгээр амиа хорлох болон дотно хүмүүсээ хөнөөхөд хүргэж болно. Зарим үед амиа хорлох явдал бүтэлгүйтэж, амьдралын нөхцөл нь өмнөхөөсөө улам бүр дордож болзошгүй юм.

7. Эвтаназийг хориглодог орнуудад тухайн хуулийг эс харгалзан эмч нар, өвчтөний гэр бүлийнхэн нь нууцаар эвтаназийг үйлдсээр байдаг. Иймээс эвтаназийг хийх явдлыг дэмжигчид эвтаназийг хуульчлахгүй бол энэ мэт нууц үйл ажиллагаа хяналтгүй болно гэсэн үндэслэлийг дэвшүүлдэг. Тэдний үзсэнээр хуулинд эвтаназийг зөвшөөрөх нь хяналттай байх, зүй бус байдлаас сэрэмжлэх бололцоог олгоно гэж үздэг

билээ.

Энэ мэтээр эвтаназийн асуудлыг олон талаас шинжилж хүний тэсвэрлэшгүй их өвдөлт, клиник үхэлд орсон байдал зэрэгт хандсан энэ амар үхлийн тухай олон сэтгэгч, мэргэжилтэн янз бүрийн үндэслэл дэвшүүлсэн байдаг юм.

Манай монголчуудын ахуй, сэтгэлгээнд байдаг соёл бол өвдөж зовсон хэнийг ч атугай амьдралын эцсийн мөч хүртэл нь асран тэтгэж, хайрлаж, амьдрах хугацааг нь уртасгахыг эрмэлзэж байдаг, түүний төлөө бүгдээ зориулдаг явдал байдаг. Харамсалтай нь өнөөдөр янз бүрийн хорт хавдар, шинэ төрлийн өвчнүүд газар авч, тэдгээрийг шийдвэрлэх асуудалд анагаах ухаан зарим тохиолдолд хүчин мөхөстөж байгаа юм. Гэхдээ энэ сэдвийг авч үзэж буй шалтгаан нь шинэ тутам үүсч байгаа, эсхүл тохиолдож байгаа харамсалтай өвчнүүдийг шийдвэрлэх тухай биш, ерөөс хүний амьдралын үнэ цэнийг ёс суртахууны болон хүний эрхийн үүднээс дахин нэг эргэцүүлэх шаардлага байгааг харуулахыг зорьсон бөлгөө.

Эдгэрэшгүй гэж оношлогдсон хүмүүсийн амийг хөндлөнгөөс зогсоох нь туйлаас харамсалтай боловч бие махбодийн тэвчишгүй өвчин шаналал, санхүү хөрөнгийн асуудал, сэтгэл санааны хямрал зэрэг олон бэрхшээлийг цэглэдэг рационал үйлдэл болдог ч хүний амьд байх эсэх асуудлыг шийдэх эрх бусдад болон хамгийн гол нь тэр хүнд өөрт нь бий юу гэдгээс л хүний оршихуй, ёс суртахуун, амьдралын утга учрын тухай философийн олон эргэлзээт асуудал үүдэн гардаг билээ.

НОМ ЗҮЙ

1. С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг. УБ., 2010
2. Философи эхлэн сурах бичиг. УБ., 2000 //Нээлттэй философи нийгэмлэг//
3. Платон. Төр улс. УБ., 2005
4. М.Цэрэнбат. Эвтанази ба үхэх эрх. УБ., 2012
5. Judith A.Boss. Ethics for life. USA. 1998
6. Martin Heidegger. Being and Time. USA, 2008
7. Steven Luper. A Guide to Ethics. USA, 2002
8. Sir Thomas More. Utopia. Dover Publications, INC. 1997
9. <http://www.euthanasia.cc/telfer.html>
10. <http://plato.stanford.edu/entries/euthanasia-voluntary/>
11. <http://www.assa.mn/content/6589.shtml?a=social>
12. https://www.academia.edu/1407390/Immanuel_kants_Moral_theory_as_a_response_to_euthanasia
13. https://en.wikipedia.org/wiki/Secular_ethics
14. <http://www.life.org.nz/euthanasia/abouteuthanasia/history-euthanasia1/>
15. <http://www.mongolmed.mn/article/4925>

ABSTRACT

(Euthanasia: Philosophical speculation on rights to die)

The authors of this paper intended to show that importance of concept of euthanasia as applied ethical problem. This act and concept have been always controversial in medical ethics, philosophy and legal environment. Euthanasia is the termination of an incurable illness person's life in order to relieve them of their suffering.

There are a number of arguments in favor of and against this issue. Nevertheless the issue is clear, society demands right decision to its application. Thus the paper tries to set the issue of euthanasia in some philosophical theories. In this paper authors shall concentrate on the controversial issues: whether it is morally permissible for professionals and family members even in the society.

Also the paper tries to show in outline how various well-known philosophical theories of morality can be applied to the dilemma of death with dignity and welfare of the society. The authors argued that none of these theories need be interpreted as or a convincing justification of this problem.